
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/08 тоот тушаалын ёсдүгээр хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.01.20	Хуудасны тоо: 4
Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан		Танилцах албан тушаалтнууд: Нийт багш, суралцагчид	

“СУРАЛЦАГЧДАД ДЭМЖЛЭГ, ТЭТГЭЛЭГ ҮЗҮҮЛЭХ” ЖУРАМ

Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:
Хувилбарын дугаар: V1.2026

Түгээлт




Энэ журам нь манай байгууллагын өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ журмын батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

ЗӨВШӨӨРӨЛ

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү журмыг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
Боловсруулсан	Нийгмийн ажилтан	Батжаргал Мөнхдэлгэр	2026.01.16	
Хянасан	Сургалтын менежер	Лувсандорж Чингэрэл	2026.01.19	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.01.20	

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмын өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт журамд орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

НЭГ.Нийтлэг үндэслэл.....	1
ХОЁР.Хамрах хүрээ.....	1
ГУРАВ.Хүний эрхийг хамгаалах зарчим.....	1
ДӨРӨВ.Жендерийн эрх тэгш байдлыг хангах зарчим.....	1-2
ТАВ.Суралцагчдад үзүүлэх дэмжлэг.....	2
ЗУРГАА.Тэтгэлэг, төрөл.....	2
ДОЛОО.Тэтгэлэг олгох шалгуур.....	3
НАЙМ.Тэтгэлэг олгох шалгуур.....	4
ЕС.Тэтгэлэг дэмжлэгийн олголт, хяналт.....	4



№ Ж-3-020
Суралцагчдад дэмжлэг, тэтгэлэг үзүүлэх журам
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20
Хувилбар: V1.2026
Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй

Нэг.Нийтлэг үндэслэл

Энэхүү журам нь суралцагчдын сурч боловсрох эрхийг хангах, тэдэнд боловсролын тэгш хүртээмжийг олгох, жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих, хүний эрхийг хамгаалах зорилготой. Журам нь суралцагч бүрийн онцлогт нийцсэн тэтгэлэг, дэмжлэгийг үзүүлэх зарчмыг баримтална.

Хоёр.Хамрах хүрээ

ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн оюутнууд

Гурав.Хүний эрхийг хамгаалах зарчим

3.1.Суралцагч бүр үндэс, угсаа, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, үзэл бодлоос үл хамааран тэгш эрхтэй байна.

3.2.Бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг хориглож, хүний эрхийн мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлнэ.

3.3.Суралцагчдын нэр төр, халдашгүй байдлыг хамгаалж, аливаа дарамт шахалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

3.4.Боловсролын байгууллагууд хүний эрхийн сургалт, мэдлэг олгох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

Дөрөв.Жендерийн эрх тэгш байдлыг хангах зарчим

4.1.Сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаанд жендерийн эрх тэгш байдлыг хангасан бодлого хэрэгжүүлнэ.

4.2.Боловсролын байгууллагын орчинд хүйсийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхах аливаа хандлагыг таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

	<p>№ Ж-3-020 Суралцагчдад дэмжлэг, тэтгэлэг үзүүлэх журам</p> <p>Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй</p>
---	---	--

4.3.Эмэгтэй, эрэгтэй суралцагчдын боловсролын хүртээмжийг сайжруулж, тэгш оролцоог хангасан бодлогыг баримтална.

4.4.Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендэрийн талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх сургалтуудыг зохион байгуулна.

Тав.Суралцагчдад үзүүлэх дэмжлэг

5.1.Суралцагчдын нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг авах боломжийг хангаж, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлнэ.

5.2.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад тэгш оролцоог хангах зорилгоор хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.

5.3.Санхүүгийн болон материаллаг дэмжлэг шаардлагатай суралцагчдад тэтгэлэг, дэмжлэг урамшууллын боломжийг олгоно.

5.4.Сургалтын хөтөлбөрийг суралцагчдын хэрэгцээнд нийцүүлэн уян хатан зохицуулж, сурах боломжоор хангана.


5.5.Сурах нөхцөлийн дэмжлэг (дотуур байр, хувийн хамгаалах хэрэгсэл)

5.6.Амьжиргааны түвшин доогуур өрхийн суралцагчдад жилд 1 удаа хөдөлмөр хамгааллын хувцсаар хангана.

Зургаа.Тэтгэлэг, төрөл

6.1.Суралцагчдад дараах төрлийн тэтгэлэг олгоно:

- сурлагын амжилтаар олгогдох тэтгэлэг;
- улсын чанартай тэмцээн уралдаанд оролцож эхний 3 байранд шалгарсан тохиолдолд;
- тэтгэлэгт техникчийн анги;
- дэмжлэг үзүүлэхэд мэргэжлийн боловсролын сургалтууд хамаарна;

 <p>ОМНОГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ</p>	<p>№ Ж-3-020 Суралцагчдад дэмжлэг, тэтгэлэг үзүүлэх журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд</p>	<p>Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй</p>
--	--	--

Долоо.Тэтгэлэг олгох шалгуур

7.1.Сурлагын амжилтаар олгох тэтгэлгийн шалгуур. Үүнд:

- техникчийн ангийн оюутан байх;
- ёс зүйн дүрмийн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх;
- суралцах хугацаандаа онол, дадлагын сургалтад дунджаар 80-аас дээш хувийн ирцтэй хамрагдсан байх;

7.2.Санхүүгийн хэрэгцээнд тулгуурласан дэмжлэгийн шалгуур. Үүнд:

- өрхийн орлого тодорхой түвшнээс доогуур байх;
- гэр бүлийн онцгой байдал (хөгжлийн бэрхшээлтэй, өнчин, олон хүүхэдтэй);
- нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг айл өрхийн суралцагч;
- нэг өрхийн 3-аас дээш хүүхэд ЕБС, МБСБ-д суралцдаг эсэх;
- өрхийн орлогын түвшин доогуур хагас болон бүтэн өнчин суралцагч;
- суралцагч сурах хугацаанд шалгуурт нийцэн 1 удаагийн дэмжлэг авах хүсэлт ирүүлнэ;

7.3.Онцгой авьяас, ур чадварын тэтгэлэг. Үүнд:

- техникчийн ангид үйлчилнэ;
- улс, олон улсын түвшинд амжилт гаргасан байх (эхний 3 байр);
- урлаг, спорт, мэргэжлийн боловсролын тэмцээнд амжилттай оролцсон байх;

III байр – 30%

II байр – 40%

I байр – 50% - ийн тэтгэлэг урамшуулал

 <p>ОМНІГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ</p>	№ Ж-3-020 Суралцагчдад дэмжлэг, тэтгэлэг үзүүлэх журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Зөвхөн дотоод хэрэгцээнд- Нээлттэй
--	---	---

Найм.Тэтгэлэгийн хүсэлт гаргах, сонгон шалгаруулах

8.1.Суралцагчид тэтгэлэгийн хүсэлтээ дараах байдлаар гаргана. Үүнд:

- гар өргөдөл
- шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлэх (ирцийн нэгтгэл, дүнгийн хуулбар);

8.2.Сонгон шалгаруулалт дараах үе шаттай байна. Үүнд:

- анхан шатны шалгаруулалт (баримт бичгийн бүрдүүлэлт);
- ярилцлага, нэмэлт шалгалт (шаардлагатай бол);
- шийдвэр гаргах;

Ес.Тэтгэлэг дэмжлэгийн олголт, хяналт

9.1.Тэтгэлэг, дэмжлэгт тэнцсэн суралцагчдын нэрсийг зарлаж, тэтгэлэг олгоно.

9.2.Тэтгэлэгийн зарцуулалтад хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд тайлан гаргуулна.